



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 8/90

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Жуулчны баазад тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батсарай ХХК-ний “Зайсан гейт” зочид буудлын 16/135, Боржигоны бичээч ХХК-ний “Кинг 1” зочид буудлын 12/243, Холбоо ус ХХК-ний “Чандмань” зочид буудлын 13/151, Боржигоны бичээч ХХК-ний “Кинг 2” зочид буудлын 16/044, ЭБ-Ану ХХК-ний “ЭБ” зочид буудлын 16/106, Тахилга ХХК-ний “Топаз” зочид буудлын 14/44, Сант асар ХХК-ний “Сант асар” зочид буудлын 16/145, Эс Пи Би ХХК-ний “Соёмбо” Дэн буудлын 14/86, Тонхил нуур ХХК-ний “Молор” дэн буудлын 16/095, Дэлгэрэнт трейд ХХК-ний “Санрайс” дэн буудлын 15/099, Цог ХХК-ний “Цог” дэн буудлын 16/085, Уран зандштайн ХХК-ний “Хотару” дэн буудлын 16/102, Иргэн Л.Мөнхбаатар “Эл Ти” дэн буудлын 16/170, Мөнхийн сарнай ХХК-ний “Сарнай” дэн буудлын 16/087, Гангар од ХХК-ний

"Жи Эм Жи" дэн буудлын 16/091, Отгонжолоо ХХК-ний "Зочин" дэн буудлын 13/103, Иргэн Д.Октябрь "Окей 32" дэн буудлын 13/219, Молбаттал ХХК-ний "Лаурус" дэн буудлын 13/273 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Терийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 12 сарын 13
өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.12.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сант Асар ХХК	2627655	Сант асар	СБД-ийн 2-р хороо Сөүлийн гудамж 14
2	Тахилга ХХК	2062054	Топаз	СБД-ийн 10-р хороо 7-р хороолол 34-01
3	Эб-Ану ХХК	5913349	ЭБ	БЗД-ийн 14-р хороо 13-р гудамж
4	Боржигоны бичээч ХХК	5439787	Кинг-2	БЗД-ийн 8-р хороо 11-276
5	Холбоо ус ХХК	2601273	Чандмань	СХД-ийн 15-р хороо Барилгачин гудамж
6	Эс Пи Эйч ХХК	5799236	Мандарин	БЗД-ийн 22-р хороо ЭТӨЧ-84
7	Эй Би Эм Эй ХХК	2546876	Аз	ЧД-ийн 3-р хороо Төмөрчин гудамж
8	Эрчимт Болор ХХК	5098521	Болор	СХД-ийн 1-р хороолол 13-р хороо Залуус 7-1
9	Боржигоны бичээч ХХК	5439787	Кинг-1	БЗД-ийн 2-р хороо Цэргийн хотхон 258
10	Өнцаг-Өлзийбаян ХХК	5531934	Өнцаг	СХД-ийн 7-р хороо Баянхшуу 6-54
11	Батсарай ХХК	2584905	Зайсан гайт	ХУД-ийн 11-р хороо Зайсан Дунжингарав-12

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 10 сарын 12 өдрийн Н.С. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2017.12.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Отгонжолоо ХХК	2554569	Зочин	СХД-ийн 12-р хороо
2	Дархан цогт ХХК	5000165	Дөл	СХД-ийн 11-р хороо АОС 3-2
3	Гангар од ХХК	2847264	Жи Эм Жи	СХД-ийн 9-р хороо Баруунбаян уулын 1-1
4	Мөнхийн сарнай ХХК	2571668	Сарнай	БГД-ийн 3-р хороо Замчдын 8-3
5	Иргэн Л.Мөнхбатар	УХ83022414	Эл Ти	БГД-ийн 8-р хороо 13-р байр 111
6	Уран зандштайн ХХК	5653614	Хотару	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ-170-р байр
7	Цог ХХК	2020165	Цог	ЧД-ийн 5-р хороо Бага тойруу 21-2
8	Дэлгэрэнт трейд ХХК	2613093	Санрайс	БЗД-ийн 13-р хороо Нарны зам
9	Тонхил нуур ХХК	2557959	Молор	БЗД-ийн 7-р хороо Доржийн 3-1
10	Эс Пи Би ХХК	2855941	Соёмбо	СБД-ийн 16-р хороо 34-04
11	Би Би Эйч Эйч ХХК	5134129	Ивээл	СХД-ийн 13-р хороо 198-1
12	Мондрагонишими ХХК	5666848	Грийн	СХД-ийн 13-р хороо Өнөр 1966
13	Молбаттал ХХК	5004527	Лаурус	СХД-ийн 14-р хороо 12-54
14	Иргэн Д.Октябрь	ЦБ52100177	Окей 32	ЧД-ийн 11-р хороо Нуурын 22-514

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын дарын 2017 оны 11 сарын 15
өдрийн 11:00 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.12.13

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Чингис хааны хүрээ ХХК	5619661	Чингис хааны хүрээ	ХУД-ийн 8-р хороо Жаргалантын ам
2	Вэржин тэрритори ХХК	5044626	Хотула Лодж	НД-ийн 6-р хороо Горхи тэрэлжийн БЦГ Эрээний ам

--ooOoo--